

Хүүхэд бүрд итгэл найдвар,
баяр баясал, тэгш байдал

World Vision
ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ



МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА

ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

Зураг дээр: Бага ангийн сурагчид хичээл завсарлах үеэр,
Архангай аймгийн 3-р сургууль



03

ХӨТӨЛБӨРИЙН МЭНДЧИЛГЭЭ

04

ТАНЫ АСААСАН ГЭРЭЛ

05

ХӨТӨЛБӨРИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

06

ХӨТӨЛБӨРӨӨС ЗАРЛАДАГ АЯНУУД

08

ИВЭЭН ТЭТГЭГЧИЙН АЯЛАЛ

09

2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮНДЭСНИЙ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүүхэд бүрийн бүрэн дүүрэн амьдралын төлөөх эрхэм зорилгод хүрэхийн тулд нийт донорууд, хамтрагчид, ивээн тэтгэгчдийнхээ дэмжлэгтэйгээр өнгөрсөн жилийн туршид хийсэн ажлын үр дүн, амжилтаа энэхүү тайлангаар хуваалцаж байгаадаа туйлын баяртай байна. Бид 2023 онд хүүхдийн хөгжил, оролцоог дэмжиж, хүүхэд, гэр бүлийн аж байдлыг сайжруулах чиглэлээр хөтөлбөр хэрэгждэг Архангай, Өвөрхангай аймаг, Эрдэнэт, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт нийт 2,100 гаруй эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, тусламж дэмжлэг нэн шаардлагатай хүүхдүүдэд хүрч ажилласан байна.

Хүүхэд бүрийн бүрэн дүүрэн амьдралын төлөө биднийг дэмжин, хамтран ажиллаж ирсэн нийт ивээн тэтгэгчид, түншлэгчид, орон нутгийнхан болоод Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын нийт ажилтнууддаа чин сэтгэлээсээ талархлаа илэрхийлье!
Хүүхэд бүр хөгжих тэгш боломжоор хангагдан, итгэл найдвараар дүүрэн байж өөрийн гэрэлт ирээдүйг бүтээх болтугай!

БОЛДЫН БОЛОРЦЭЦЭГ
ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОУБ-ЫН
ҮНДЭСНИЙ ЗАХИРАЛ



Зураг дээр: Архангай аймгийн 3-р сургуулийн спортын дугуйлангийн сурагчдын төлөөлөл н.Болорчимэг, М.Бүжинлхам нар



Зураг дээр: Хүүхдийн номын сантай болсон хүүхдүүдийн төлөөлөл
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот

ТАНЫ АСААСАН ГЭРЭЛ

Ч.МЯГМАРСҮРЭН
ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАХ АЖИЛТАН

Монголчууд бидний “Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусал” гэж хэлдэг нь их бага гэлгүй бусдад тус дэм өгч явахыг ахуй соёлтойгоо холбон таниулсан хэлц юм. Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн ивээн тэтгэгч, дэмжигч бүрийн сэтгэлийн хандив нь хөтөлбөрийн хүүхдүүдэд дулаан гэр орон, хувцас, хоол хүнс, бусад хүүхдүүдээс хоцрохгүй хөгжиж оролцох боломж болон очиж хүүхдийн амьдралд итгэл найдварын гэрэл асаадаг.

2023 оны 4-р сард Архангай аймаг дахь хөтөлбөрийн хүүхдүүдтэй уулзах боломж надад тохиосон юм. Аймгийн төвийн зүүн хойд талын хадтай уулыг даваад нэг айлд очсон нь хөтөлбөрт хамрагдаад шинэ гэртэй болсон залуухан бүсгүйнх байв.

Гэрийн гадаа 4 орчим насны жаахан хүү, бага сургуулийн бололтой турьхан охин, дүү нараа бөөцийлөх өсвөр насны болов уу гэмээр жаал охины хамт байх бөгөөд ээж нь түлээнд явсан эзгүй байж таарав.

МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА ХӨТӨЛБӨР

Охин биднийг гэртээ орохыг уриад, дүү нараа дагуулан орж ирэв.


Гэрийн зүүн урд хэсэгт байх тавиур дээр хэдэн аяга халбага, алчуур, тулганд тавьсан тогоонд хоносон болов уу гэмээр гурилтай шөл харагдахаас өөр идэх зүйл харагдсангүй.

"Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн ивээн тэтгэгч, дэмжигч бүрийн сэтгэлийн хандив нь хүүхдийн амьдралд итгэл найдварын гэрэл асаадаг."

Том охин Дэлхийн зөнгийн ах эгч ирсэн хэмээн баярлаж шинэ гэртэй болсон, дулаахан байгаа, одоо хичээлээ л сайн хийнэ гээд инээмсэглэн ярих аж. Ажиглахад гэрт охинд суугаад хичээл хийх ширээ, модон тавцан ч болтугай харагдсангүй. Хэсэг ярилцсаны дараа хичээлээ яаж хийдэг вэ гээд асуутал орны толгой тушаа хэсэгт цүнхээ хэвтүүлж тавиад дээр нь дэвтрээ дэлгэж үзгээ бариад ингээд хийдэг гэж харууллаа.

Ээждээ туслан маргаашид тэмүүлэх охины нүд гэрэлтэж байсан.

*2023 онд хөтөлбөрт хамрагдсан 58 хүүхдийн гэр бүлд 5 ханатай, давхар дээвэр туургатай үндэсний шинэ гэр буцалтгүй нөхцөлөөр олгосон.



МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА ХӨТӨЛБӨРТ

2,163 хүүхэд бүртгэлтэй байгаагийн **1,586** нь ивээн тэтгэгчтэй байна. Хамгийн олон хүүхэд дэмждэг ивээн тэтгэгч **4** орон нутгийн **13** хүүхэд ивээн тэтгэдэг. Ивээн тэтгэгчдийн **19.2%** нь 2023 оны хандиваа тасралтгүй өгсөн байна.

ХӨТӨЛБӨРИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Хөтөлбөрийн зорилго: Орон нутгийн түншлэгчид, сайн дурынхны оролцоо, итгэл хүлээсэн ивээн тэтгэгчдийн тасралтгүй дэмжлэгтэйгээр хөтөлбөрийн хүүхдүүдийн хөгжил, оролцоог хангаж, чадваржуулна.





Зураг дээр: Сургуульд бэлэн аянд хамрагдсан хүүхдүүдийн төлөөлөл Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот

...Би саяхан МСҮТ-д үйлдвэрийн цахилгаанчны ангид элсэж, шинэ сургуульд орсон. Таны өгсөн цүнх, хичээлийн хэрэгслийг авсан. Ээж маань байнга өвддөг тул дүү бид хоёр хичээлийн хэрэгслээ бэлтгэж амжаагүй байсан юм. Тэгтэл бэлэг ирж, би цүнх болон хичээлийн хэрэгсэлтэй болсон. Дүү маань нэгдүгээр анги учраас харандаа, цабуу, үзэг гэх мэт зүйлсийг би дүүдээ өгч, цүнх болон дэвтрүүдээ өөрөө хэрэглэсэн. Таны явуулсан хэрэгсэл маш их хэрэг болсон Танд маш их баярлалаа....

Сургуульд бэлэн аяны багц хүлээн авсан хүүхдийн захианаас

2023 оны “Сургуульд бэлэн” аяны хүрээнд хөтөлбөрт хамрагддаг **654** хүүхэд хичээлийн хэрэгсэлтэй болсон. Аяны хүрээнд 2 төрлийн багц хүүхдүүдэд хүргэсэн.

- 354 хүүхэд Цүнх + Хичээлийн хэрэгслэл
- 300 хүүхэд Хичээлийн хэрэгслэл

“ХАМТДАА ДАВЪЯ”, “СУРГУУЛЬД БЭЛЭН” АЯНУУД

Хөтөлбөрөөс жил бүрийн өвөл, хавар, намрын улирлуудад тогтмол зарлагддаг аянууд нь:

- 12-р сарын 1-нээс 3-р сарын 30 хүртэл хугацаанд “Дулаан өвөлжье” аян
- 8-р сарын 1-нээс 9-р сарын 30 хүртэл “Сургуульд бэлэн” аян

“Хамтдаа давъя” уриан дор **204** хувь хүн, **54** төрийн болон ТББ, **19** хувийн хэвшил, 14 аймаг сум дүүргийн удирдах байгууллагууд нэгдэн **135** сая **755** мянган төгрөгийн хандивыг бүрдүүлж чадсан.

Аяны хандиваар Баянхонгор, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг болон Багануур дүүргийн олон ам бүлтэй, амьжиргааны түвшин доогуур нийт **780** малчин өрхийн **3,650** хүн үүнээс **2,250** гаруй хүүхдэд хатуу өвлийг сэтгэлийн дулаантай давахад нь хувь нэмэр орууллаа.



Зураг дээр: Хамтдаа давъя аянд хамрагдсан хүүхдүүд

654

Хөтөлбөрт хамрагддаг **654** хүүхэд "Сургуульд бэлэн" аяны хүрээнд бэлдсэн хичээлийн хэрэглэлийн багц хүлээн авсан. 354 хүүхдэд цүнхтэй бичиг хэргийн багц, 300 хүүхдэд бичиг хэргийн багц хүргэгдсэн байна. Нийт **119** ивээн тэтгэгч **147** хичээлийн хэрэгслийн багц бэлдэн хүүхдүүддээ илгээсэн байна.

31%

Хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн 31% буюу **674** хүүхэд 2022-2023 онд хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, клубт хамрагдсан байна. Энэ боломж Архангай аймгийн хүүхдүүдэд арай илүү буюу **57%** байгаа нь хамтран ажиллаж буй сургууль багш нарын оролцоо, дэмжлэгийн үр дүн юм.

3%

Хөтөлбөрт хамрагдсан **58** өрх буюу **3%** нь шинэ гэр оронтой болсон.

- Архангай - **14** өрх
- Сонгинохайрхан - **28** өрх
- Эрдэнэт - **9** өрх
- Өвөрхангай - **7** өрх

Энэхүү өрхүүдэд нийт **163** хүүхэд эцэг эх, асран хамгаалагчийн хамт амьдарч байна.

Зураг дээр: Хүүхдийн дүү хоолой хэлэлцүүлгийн үеэр, Улаанбаатар хот

ИВЭЭН ТЭТГЭГЧИЙН АЯЛАЛ

“Хүүхэд ивээн тэтгэнэ гэдэг нь тодорхой санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн мөнгөтэй хүн хийдэг байх гэж боддог байлаа. Гэтэл Дэлхийн зөнгийн ажилтантай уулзаад ярилцаж суухдаа би ч гэсэн ивээн тэтгэгч болж болох юм байна гэдгийг ойлгосон” хэмээн Оюунмин яриагаа эхэлсэн юм.

Тэрээр 2023 оны 3-р сард Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн ивээн тэтгэгч болсон ч өнгөрсөн нэг жил хүрэхгүй хугацаанд чамгүй “урт аялал” эхлүүлээд явж байна.

“Ивээн тэтгэгч болох шийдвэр гаргаж байх үед би бага насны хоёр хүүхдээ өсгөөд, гэрийн ажилтай байдаг байсан. Эхэндээ сар бүр тогтмол хандив өгнө гэдэгтээ итгэлтэй байгаагүй ч эргээд харахад би зөв шийдвэр гаргаснаа ойлгосон. Миний дэмждэг хүүхэд маань 5 настай бяцхан охин байдаг. Гэхдээ миний ивээн тэтгэх хүсэл 1 хүүхдээр зогсоогүй юм. Би өөр яаж ивээн тэтгэж болох талаар Дэлхийн зөнгийнхөнтэй дахин уулзаад нэгэн сайхан санал дээр нэгдсэн нь Киокушин каратегийн дугуйлан эхлүүлэх байсан” гэж тэрээр яриагаа үргэлжлүүлээ.

Дугуйланг маань сонирхож 6 хүүхэд ирснийг мэдээд маш их баярлаж урам зоригтойгоор дугуйлангаа эхлүүлж байлаа гээд инээмсэглэх Оюунмин багш “Би өөрөө каратегээр дамжуулан олон сайн зан чанар, найз нөхөд, хамт олонтой болсон. Надад олдсон боломжуудыг

МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА ХӨТӨЛБӨР



Зураг дээр: Дасгалжуулагч О.Оюунмин, Тэлмэнжаргалын хамт Киокушин каратегийн УБ хотын аварга шалгаруулах тэмцээний үеэр

“Дугуйланг маань сонирхож зургаан хүүхэд ирснийг мэдээд маш их баярлаж урам зоригтойгоор дугуйлангаа эхлүүлж байлаа”

хүүхдүүдэд олгохыг хүссэн” гэж даруухнаар зорилгоо илэрхийлсэн юм.

Түүний хоёр шавь 2023 оны 9-р сарын 23-нд цагаан бүсний шалгалтаа өгөөд тэнцсэн. Удалгүй 10-р сарын 1-нд хөвгүүд Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцож,

- Алтанхундага - Ганцаарчилсан ката төрөлд /анхан шат, 12-14 нас/-аас хүрэл медаль,
- Тэлмэнжаргал - Ганцаарчилсан ката төрөлд /анхан шат, 10-11 нас/ хүрэл медаль тус тус авсан байна.

2023 ОНЫ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн тайлант хугацааны санхүүжилт **245,607** ам.доллартай тэнцэж байна.

Төрлөөр ангилбал:

Нийт санхүүжилтийн **35.6%** буюу **87,395** нь хүүхдийн хамгаалал, оролцоо, хөгжлийг дэмжсэн ивээн тэтгэгчийн сар бүрийн тогтмол хандив, **4%** буюу **9,852** ам.доллар нь хүүхдийн сайн сайхныг дэмжиж мөнгөн болон материаллаг зүйлс хандивласан хувь хүн, хамт олны дэмжлэгээс, **21.2%** буюу **51,993** ам.доллартай тэнцэх тусламжийг хүүхдүүдийн хичээлийн бэлтгэлд зориулсан “Сургуульд бэлэн” болон “Дулаан өвөлжье” аянуудад ивээн тэтгэгч, хувь хүн, компани, байгууллагуудын зүгээс өгсөн хандив бүрдүүлсэн бол гадаад хөрөнгө оруулалтын Гэрээр бэлэг барья төсөл **84,314** ам.доллар (**34.3%**), Хонь төсөл **4,636** ам.доллар (**1.9%**), тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эрүүл мэндийг дэмжих төсөл **7,417** (**3%**) ам.долларын төслийн санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Ивээн
тэтгэгчийн
хандив

36%

Мөнгөн болон
мөнгөн бус
хандив

4%

Кампанит
аянууд

21%

Гэрээр бэлэг
барья төсөл

34%

Эрүүл мэндийн
төсөл


3%

Хонь төсөл

2%

2023 ОНЫ


ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ



Төсвийн хувьд өмнөх жилүүдээс ялгаатай нь хүүхдийн амьдарч буй аж байдлыг сайжруулахад 56.8% -г зарцуулжээ.

2023 онд нийт 400 гаруй хүүхэд хөтөлбөрт шинээр нэмж бүртгэсэн. Шинээр бүртгэгдсэн хүүхдүүдийн аж байдал маш хүнд (орон гэргүй болсон, асран хамгаалагчаа алдсан, гамшиг осолд өртсөн гм) байсан нь төсвийн зарцуулалтад нөлөөлсөн байна.

Графикаар ивээн тэтгэгчийн хандивыг (сая төгрөгөөр) хөтөлбөр хэрэгжиж буй орон нутаг тус бүрээр задалж харууллаа.



**2023 оны турш Монголчууд
Монголчууддаа хөтөлбөрөө чин
сэтгэлээсээ дэмжсэн бүх ивээн тэтгэгч,
дэмжигч, хамтран ажиллагч
байгууллагууд, сайн дурынхандаа
хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагчид
болон нийт хамт олныхоо зүгээс
талархал илэрхийлье.**



Бидэнтэй холбогдох

Дэлхийн Зөн Монгол ОУБ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо,
13-р хороолол, Соманг Плаза, 4-р давхар
Холбогдох утасны дугаар: +(976) 99097753



worldvisionmongolia@wvi.org 

@worldvisionmongolia 

**ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОУБ
МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА
ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН 2023**